Ректорын 2024 оны 08 -р сарын
26 өдрийн 183 тоот
тушаалын хавсралт № 1

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ХОЛБООНЫ ДҮРЭМ

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Нэгдүгээр зүйл. Дүрмийн зорилт

1.1. Энэ дүрмийн зорилт нь Отгонтэнгэр их сургуулийн /цаашид ОТИС гэх/ Оюутны холбоо /цаашид ОХ гэх/, бүтцийн сургуулийн Оюутны зөвлөл /цаашид ОЗ гэх/-н зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, зарчим бүтэц, зохион байгуулалт, гишүүдийн эрх үүрэг, ОХ-ны чиглүүлэгч багш, гишүүд, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа, эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. ОТИС-ийн ОХ нь ОТИС-ийн нийт оюутны эрх, ашиг сонирхлыг илэрхийлсэн гишүүнчлэл бүхий нэгдэл бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, ОТИС-ийн дүрэм, дотоод журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, нийгэм болон оюутанд үйлчилдэг ашгийн төлөө бус гишүүнчлэл бүхий нэгдэл юм.

1.3. ОТИС-ийн ОХ нь ОТИС-ийн оюутны эрх барих, дээд байгууллага мөн.

1.4. ОХ нь өөрийн бэлгэдэл, хэвлэмэл хуудас, тамгатай байна.

Хоёрдугаар бүлэг. Зорилго, зарчим, үйл ажиллагааны үндсэн чиглэл

Хоёрдугаар зүйл. Зорилго

2.1. ОТИС-ийн ОХ-ны эрхэм зорилго нь тус сургуульд суралцаж буй Монгол Улсын ирээдүй болсон оюутнуудыг амжилттай суралцах, өөрийгөө хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, оюутнуудын идэвх оролцоог сайн дурын үндсэн дээр нэмэгдүүлж, тэдний эв нэгдлийн илэрхийллийг бий болгох.

2.2. ОТИС-ийн оюутнуудын эрх ашгийг хамгаалах, оюутныг бүх талаар хөгжүүлэх, нийгэмд бие хүн бэлтгэх цогц үйл ажиллагааг зохион байгуулах, сургуулиа төлөөлөх, оюутнуудаа бусад сургуулиудын оюутнуудтай холбох, салбар сургуулиудын ОЗ-үдийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, нэгдмэл удирдлагаар хангахад оршино.

2.3. ОТИС-ийн ОХ нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд зорилтуудаа тодорхойлон гишүүдийн олонхын саналаар баталгаажуулан хэрэгжүүлнэ.

Гуравдугаар зүйл. Үйл ажиллагааны үндсэн зарчим

3.1. ОТИС-ийн ОХ нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд зорилтуудаа тодорхойлон гишүүдийн олонхын саналаар баталгаажуулан хэрэгжүүлнэ.

3.1.1. ардчилал, шударга ёсны зарчим
3.1.2. удирдах, удирдуулах ёсны зарчим
3.1.3. ил тод байдлын зарчим
3.1.4. нэгдмэл удирдлагын зарчим
3.1.5. байнгын тогтвортой, залгамж чанартай байх зарчим
3.1.6. хариуцлага тооцдог, ёс зүйтэй байх зарчим
3.1.7. харилцан итгэлцэл, идэвх санаачилгатай, сайн дурын байх зарчим
3.1.8. дүрмээ даган биелүүлэх зарчим гишүүдийн тэгш эрхийн зарчим

Дөрөвдүгээр зүйл. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

4.1. ОТИС-ийн ОХ нь дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

4.1.1. сургуулийн нийт оюутнуудын хууль ёсны эрх ашгийг хамгаалах

4.1.2. нийт оюутнуудыг ОТИС, Монголын оюутны холбоо болон бусад байгууллага, албан тушаалтантай харилцахад төлөөлөх

4.1.3. оюутныг хөгжүүлэх, дэмжих, нийгэмд бие хүн бэлтгэх бүх төрлийн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах

4.1.4. оюутны бүх төрлийн санаачилгыг дэмжих

4.1.5. оюутны бүх чиглэлийн клубийн үйл ажиллагааг дэмжих

4.2. ОТИС-ийн ОХ нь эрхэм зорилгоо хэрэгжүүлэх явцдаа гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ОТИС-ийн ОХ-ны хэтийн төлөвлөгөөг цаг тухайд нь боловсруулж тус байгууллагын хөгжил, байнгын ажиллах баталгааг хангах, эдийн засаг, санхүүгийн боломжийг дээшлүүлэх, нийгэмд өрсөлдөх чадавхыг нь бэхжүүлэхэд чиглүүлнэ.

Гуравдугаар бүлэг. Бүтэц, зохион байгуулалт, эрх үүрэг

Тавдугаар зүйл. ОХ-ны чуулган

5.1. ОХ-ны эрх барих дээд байгууллага нь ОХ-ны чуулган /цаашид "Чуулган" гэх/ байна.

5.2. Чуулган нь жилд нэг удаа зохион байгуулагдах бөгөөд ээлжит бус чуулганыг зохион байгуулж болно. Ээлжит бус чуулганыг ОХ-ны чиглүүлэгч багш, ОХ-ны тэргүүн нар дангаараа санаачилсан, эсхүл ОХ-ны гишүүдийн 2/3-н хүсэлт гаргасан бол тус тус зарлан хуралдуулна.

5.3. Чуулган нь дараах бүрэн эрхтэй байна:

5.3.1. ОХ-ны дүрмийг батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, зорилго, зорилт тодорхойлох, төлөвлөгөө, тайлан, төсөв хэлэлцэх, батлах,

5.3.2. бүх нийтийн сонгуулиар сонгогдсон тэргүүнийг батламжлах,

5.3.3. тэргүүний ажлын тайланг дүгнэх, үүрэгт ажил хангалтгүй гэж үзвэл огцруулж, дараагийн тэргүүнийг сонгох,

5.3.4. тэргүүний санал болгосноор ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох, чөлөөлөх, эгүүлэн татах,

5.3.5. ОХ-ны бусад 9 гишүүнийг томилох, чөлөөлөх, эгүүлэн татах,

5.3.6. ОХ-ны бусад бүрэн эрх

Зургаадугаар зүйл. ОХ-ны хурал

5.1. ОХ нь тэргүүн, нарийн бичгийн дарга /цаашид "НБД" гэх/, 9 гишүүнээс бүрдэнэ. ОХ-ны хуралд бусад гишүүдийг оролцуулахаар бол саналын эрхгүй оролцоно.

5.2. ОХ-ны үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх бөгөөд ээлжит болон ээлжит бус байна. Ээлжит хурлыг 7 хоног бүрд 1 удаа тогтмол хуралдуулах бөгөөд хурал хийх өдрийг ОХ-ны тэргүүн, түүний эзгүйд НБД шийднэ.

5.3. Ээлжит бус хурлыг бүх гишүүдийн 2/3 нь хүсэлт гаргасан, мөн тэргүүн, түүний эзгүйд НБД санал болгосноор тус тус зарлан хуралдуулна.

Долоодугаар зүйл. ОХ-ны хурлын дэг

6.1. Нийт гишүүдийн гуравны хоёр буюу 6-н гишүүнээс дээш тооны гишүүн ирснээр хурлыг хүчинтэйд тооцно.

6.2. Хурлыг ОХ-ны тэргүүн даргалах ба түүний эзгүйд НБД даргална.

6.3. Хурлын протоколыг нарийн бичгийн дарга үнэн зөв, стандартын дагуу тэмдэглэж хурлын даргалагчид шалгуулан гарын үсэг зуруулна.

6.4. Хурал эхлэхээс өмнө хэлэлцэх асуудлыг гаргасан байх ёстой бөгөөд хэлэлцэх асуудал, түүний дарааллыг ОХ-ны тэргүүн түүний эзгүйд хурал даргалж байгаа этгээд гаргана. ОХ, ОЗ-ийн гишүүд хурлаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах эрхтэй ба уг саналаа амаар болон бичгээр хурал даргалагчид урьдчилан мэдэгдэнэ.

6.5. Хурлыг хурал даргалагч нээх ба хурлын төгсгөлд дүгнэнэ.

6.6. Гишүүд хуралд саналаа хэлэх эрхтэй бөгөөд гараа өргөн хурал даргалагчаас зөвшөөрөл авсны дагуу саналаа илэрхийлнэ. Саналаа илэрхийлэхдээ дарга, гишүүдэд хүндэтгэлтэй хандаж, ёс суртахуунтай байх ба гишүүний 1 удаа саналаа хэлэх хугацаа 5 минутаас хэтрэхгүй байна.

6.7. ОХ, ОЗ-ийн нэг удаагийн хурал 2 цагаас хэтрэхгүй байна. Шаардлагатай тохиолдолд хурлын цагийг хурал даргалагч сунгаж болно.

6.8. ОХ-ны хурлаас зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр гишүүд гарна.

6.9. ОХ-ны хурлаас хоцорсон тохиолдолд хурал даргалагчаас зөвшөөрөл авч орно.

6.10. Хурлын дэгийг зөрчсөн бол хурал даргалагч эхний удаа сануулах, 2 буюу түүнээс дээш удаа зөрчвөл хурлаас хөөж гаргана. Ийнхүү хөөгдөж гарсан тохиолдолд ОХ-ны хуралд ирцийг ирээгүйгээр тооцно.

Наймдугаар зүйл. ОХ-ны чиглүүлэгч багш

5.1. ОХ нь чиглүүлэгч багштай байх бөгөөд ОТИС-ийн удирдлагаас томилогдсон багш байна.

5.2. ОХ-ны чиглүүлэгч багш нь төсөв төлөвлөгөө тайлантай танилцах, ОХ-нд үүрэг даалгавар өгөх, ОХ, ОЗ-ийн дүрмийн хэрэгжилтэй танилцах, хурлын протоколтой танилцах, шагнал урамшуулалд нэр дэвшүүлэх, эрх үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой мэдэгдэл, хүсэлт, сонордуулга, уриалга, тодорхойлолт гаргах, албан ёсны үйл ажиллагаанд оролцох мөн дүрэмд заасан бусад эрх эдэлнэ.

Есдүгээр зүйл. ОХ-ны тэргүүн

8.1. ОХ-ны тэргүүн нь нийт оюутан багш, ажилчдыг хамарч явуулсан чөлөөт сонгуулийн зарчмаар сонгогдсон, ОТИС-ийн 2 дугаар курсийн, бакалаврын зэрэг горилохоор суралцаж байгаа өдрийн ангийн оюутан байх ба ОХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулах эрх, үүрэг бүхий ОТИС-ийн нэр төрийг Монгол Улсын дээд боловсролын салбарын хэмжээнд өргөж чадах хичээл сурлага, идэвх санаачилгаараа бусдыгаа хошуучлан манлайлагч байх сонгуульт ажилтныг хэлнэ.

8.2. ОХ-ны тэргүүний бүрэн эрхийн хугацаа 2 жилийн хугацаанд үргэлжилнэ. ОХ-ны тэргүүн энэхүү дүрмийн хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Сонгогдсоноос хойш 1 жилийн дараах ээлжит чуулганаар ажлаа тайлагнаж, гишүүдийн олонхын саналаар цаашид үүрэгт ажлаа үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

8.3. ОХ-ны тэргүүн нь ОТИС-ийн оюутнуудын тэргүүн, ОХ, оюутны зөвлөлүүдийн жинхэнэ удирдагч мөн.

8.4. ОХ-ны тэргүүн сонгогдсон цагаас эхлэн ангийн дарга, ОЗ-ийн гишүүн зэрэг сургуулийн бүхий л сонгуульт ажлаас татгалзана.

8.5. ОХ-ны тэргүүн нь аль нэг сургууль төлөөлөөгүй байх ба аль нэг сургуульд давуу байдал тогтоохгүй байна.

8.6. ОХ-ны тэргүүн нь дараах бүрэн эрхийг эдэлнэ.

8.6.1. ОТИС-ийн нийт оюутнуудыг төлөөлөх

8.6.2. дүрэм, журам, шийдвэр, санал, уриалга, мэдэгдэл гарган тухайлсан асуудлаар тодорхой байр суурь баримтлан ажиллах

8.6.3. хурал даргалах, хүндэтгэн үзэх шалтгаантайгаар хурлын товыг өөрчлөх, ээлжит бус хурал зарлах, гишүүдэд хүндэтгэн үзэх шалтгаантайгаар чөлөө өгөх

8.6.4. ажлын хэсэг байгуулах, төлөөлөл томилох

8.6.5. ОХ, ОЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, үүрэг ажлаас нь чөлөөлөх, гишүүнчлэлээс хасах талаар ОХ-ны хуралд болон бичгээр санал оруулах

8.6.6. НБД-д нэрийг дэвшүүлэх

8.6.7. бүтцийн сургуулиудын ОЗ-ийн төлөвлөгөөг шаардан авч танилцах, гишүүдэд үүрэг даалгавар өгөх, хуралд нь оролцох

8.6.8. ОХ-ны төсвийг зарцуулах, хянах

8.6.9. дүрэмд заасан бусад эрх эдэлнэ.

8.7. ОХ-ны тэргүүн нь дараах үүрэг хүлээнэ:

8.7.1. сургуулийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг ОХ-ны хурал дээр цаг тухайд нь мэдэгдэх

8.7.2. үйл ажиллагааны тайлан, төсөл, төлөвлөгөөг жил бүр сургуулийн захиргаа, нийт оюутнуудад тайлагнах

8.7.3. ОХ-ны өмч, эд хөрөнгийг хариуцах, хүлээн авч дараагийн тэргүүнд хүлээлгэн өгөх

8.7.4. ОХ-ны нэр төр, үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах

8.7.5. сургуулийн удирдлага, багш нар ОЗ-ийн чиглүүлэгч багштай хамтран ажиллах

8.7.6. сургуулийн нийт оюутнуудтай хамтран ажиллах

8.7.7. ОЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

8.7.8. албан үүргээ гүйцэтгэж чадахгүй бол өөрийн хүсэлтээр албан тушаалаасаа чөлөөлөгдөх

8.7.9. дүрэмд заасан бусад үүрэг хүлээнэ.

Аравдугаар зүйл. ОХ-ны тэргүүнд нэр дэвших

9.1. Нэр дэвшүүлэх ажлыг сонгууль зарласнаас хойш 5 хоногийн дараа эхэлж 5 хоногийн хугацаанд дуусгана.

9.2. Нэр дэвшүүлэхдээ ОТИС-ийн бүтэц сургууль бүрээс нэг оюутныг нэр дэвшигчээр сонгож ОХ-нд саналаа бичгээр ирүүлнэ. Бичгээр ирүүлсэн саналыг ОХ хүлээн авч нийтэд мэдээлнэ.

Арван нэгдүгээр зүйл. Санал хураах хугацаа, саналын хуудас:

10.1. Санал хураалтад ОТИС-ийн багш, ажилтан, оюутан бүр оролцох эрхтэй.

10.2. Санал хураалтыг 08:00 цагаас 17:00 цаг хүртэл явуулна.

10.3. Саналын хуудсыг бүтэц сургуулиас томилогдсон 3 багш, 3 ажилтан, 3 оюутан тоолж нэгтгэнэ.

Арван хоёрдугаар зүйл. Санал хураах ажлыг зохион байгуулах:

11.1. Санал хураах өдрийн 08 цагт ОХ-ны бүрэлдэхүүн сонгогчдын төлөөллийг байлцуулан саналын бүх хайрцгийг нээж, шалган битүүмжилж лацадсаны дараа бүтэц сургууль бүрээс санал авах ажиллагаа явагдана.

Арван гурав дугаар зүйл. Санал тоолох:

12.1. Санал тоолох ажлыг ил тод, нээлттэй явуулна. Санал тоолоход ажиглагчид, сонгогчдын болон хэвлэл, мэдээллийн төлөөлөгчид байлцаж болно.

Арван дөрөв дүгээр зүйл. ОХ-ны НБД

13.1. ОХ-ны НБД гэж ОТИС-ийн өдрийн ангид бакалаврын зэрэг горилохоор суралцаж байгаа оюутан байх ба НБД нь ОТИС-ийн ОХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг хөтлөн явуулах эрх бүхий этгээд байна.

13.2. НБД-ыг ОХ-ны тэргүүний санал болгосноор нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно.

13.3. НБД дараах эрх эдэлнэ:

13.3.1. хурал дээр өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх;

13.3.2. хүндэтгэн үзэх шалтгаанаар ОХ-ны тэргүүн, чиглүүлэгч багшаас чөлөө авах

8.7.10. өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх

8.7.11. шагнал, урамшуулал, ажил байдлын тодорхойлолт авах

8.7.12. ОХ-ны НБД-ын бүрэн эрхийн хугацаа 1 жил байх бөгөөд 1 удаа улируулан сонгож болно.

8.7.13. дүрэмд заасан бусад эрх эдлэх.

8.8. НБД дараах үүрэг хүлээнэ.

8.8.1. ОХ-ны ээлжит болон ээлжит бус хурлын протоколыг цаг тухайд нь үнэн зөвөөр, стандартын дагуу хөтлөх, хурал даргалагчид шалгуулан гарын үсэг зуруулан баталгаажуулах

8.8.2. ОХ-ны бичиг хэргийг баримтжуулан архивжуулах

8.8.3. ОХ-ны тайлан, төсөв, төлөвлөгөөний төслийг ОХ-ны тэргүүний үүрэг болгосноор цаг тухайд нь гаргаж байх

8.8.4. хурлын ирцийг үнэн зөвөөр бүртгэх, нээлттэй ил тод байлгах

8.8.5. удирдлага болон гишүүдтэй хамтран ажиллах

8.8.6. ОХ-ны хурлын шийдвэрийг биелүүлэх

8.8.7. өөрийн үйл ажиллагааны улмаас ОХ, түүний үйл ажиллагаа, бусдад учруулсан хохирлыг бүрэн хариуцах

8.8.8. ОЗ-ийн НБД нарын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх бүхий л тайлан төлөвлөгөөг хянах, ОХ-нд төвлөрүүлэх

8.8.9. дүрэмд заасан бусад үүрэг хүлээнэ.

Арван тавдугаар зүйл. ОХ-ны гишүүн

9.1. ОХ-ны гишүүн гэж энэ дүрмийн дагуу ОХ, ОЗ-ийн саналыг үндэслэн нэр дэвшиж, ОХ-ны хурлаас дэмжигдэн гишүүнээр сонгогдсон, ОХ-г төлөөлөн ажиллаж байгаа бакалаврын зэрэг горилохоор суралцаж байгаа оюутан байна.

9.2. ОХ-ны гишүүд нь бүтцийн сургууль тус бүрээс 3, нийт 9 гишүүн байна. Бүтцийн сургууль тус бүрийн ОЗ-ийн дарга нар албан үүргийнхээ дагуу гишүүнээр шууд элсэх ба бусад 2 гишүүнийг нээлттэй чөлөөт сонгуулийг салбар сургуулийн оюутны зөвлөл дотроо зохион байгуулж сонгогдсон төлөөллийг гишүүнээр элсүүлнэ.

9.3. ОХ-ны гишүүн дараах бүрэн эрх эдэлнэ.

9.3.1. хүндэтгэн үзэх шалтгаанаар хурлаас болон бусад үйл ажиллагаанаас чөлөө авах

9.3.2. ОХ-ны хурал дээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх

9.3.3. хурлаар асуудал хэлэлцүүлэхээр санал оруулах

9.3.4. ОХ-ны тэргүүн, НБД-д нэрээ дэвшүүлэх

9.3.5. өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх

9.3.6. ажил байдлын тодорхойлолт, шагнал урамшуулал, тэтгэлэг авах

9.3.7. дүрэмд заасан бусад эрх

9.4. ОХ-ны гишүүн дараах үүрэг хүлээнэ.

9.4.1. ОТИС-ийн ОХ-ны хурлын дэгийг сахих

9.4.2. хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авснаас бусад тохиолдолд хуралд ирэх

9.4.3. ОХ-ны удирдлагаас өгсөн үүрэг даалгавар биелүүлэх

9.4.4. ОХ-ны дүрмийг дагаж мөрдөх, захирагдах

9.4.5. ОХ-ны хурлын шийдвэрийг биелүүлэх

9.4.6. удирдлага болон бусад гишүүдтэй хамтран ажиллах

9.4.7. өөрийн үйл ажиллагааны улмаас учирсан үр дагаврыг бүрэн хариуцах

9.4.8. үүрэгт ажлаа гүйцэтгэж чадахгүй, сахилгын болон ёс зүйн хувьд ОХ-ны гишүүнд тэнцэхгүй болсон тохиолдолд гишүүнээс огцрох

9.4.9. дүрэмд заасан бусад үүрэг хүлээнэ.

Дөрөвдүгээр бүлэг. ОХ-ны салбар оюутны зөвлөл

Арван зургаадугаар зүйл. Оюутны зөвлөл

10.1. ОЗ нь бүтцийн сургууль дээр энэхүү дүрмийн зорилгыг хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий тухайн бүтцийн сургуулийн оюутны төлөөлөл бөгөөд ОХ-ны салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

10.2. ОЗ нь ОХ-ны бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд төлөвлөгөө, тайлан, төсвийг ОХ-той уялдуулан ОЗ-ийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал мөн.

10.3. ОЗ-ийн хурал нь байнгын тогтмол байх ба ээлжит болон ээлжит бус хуралтай байна. Ээлжит хурлыг 7 хоног бүрд 1 удаа тогтмол хуралдуулах бөгөөд хурал хийх өдрийг ОЗ-ийн дарга, түүний эзгүйд НБД зарлан хуралдуулна.

10.4. Шаардлагатай бол ээлжит бус хурлыг хуралдуулах бөгөөд ОЗ-ийн дарга, ОЗ-ийн НБД нар зарлах ба ОЗ-ийн гишүүдийн олонхын саналаар зохион байгуулж болно. Ийнхүү гишүүдийн олонхын саналаар ээлжит бус хурал зарлан хуралдуулахдаа чиглүүлэгч багш, ОЗ-ийн дарга уг хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан мэдэгдэнэ.

10.5. ОЗ-ийн хурал нь дараах бүрэн эрхтэй.

10.5.1. ОХ, ОЗ-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах талаар санал гаргах, төслийг ОХ-нд даргаар дамжуулан өргөн барих.

10.5.2. ОЗ-ийн дарга, ОЗ-ийн НБД, гишүүн сонгох, чөлөөлөх, хариуцлага тооцох, шагнаж урамшуулах, шагналд тодорхойлох.

10.5.3. ОЗ-ийн үйл ажиллагааны хэрэгжилт, төлөвлөгөө, тайланг хэлэлцэн шийдвэрлэх, үнэлэлт дүгнэлт өгөх

10.5.4. ОЗ-ийн зорилтууд, өдөр тутмын үйл ажиллагаа, зохион байгуулалтын асуудал зэргийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

10.5.5. ОЗ-ийн хуралтай холбоотой бусад асуудлыг хурлын дэгээр зохицуулна. Хурлын дэг нь ОХ-ны хурлын дэгтэй нэгэн адил байна.

Арван долоодугаар зүйл. ОЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн

11.1. ОЗ-ийн бүтцийн сургуулийн захиргаанаас томилогдсон чиглүүлэгч багш, ОЗ-ийн дарга, ОЗ-ийн НБД, орон тооны гишүүд буюу сайн дурын үндсэн дээр өөрийн хүсэлтээр Оюутны Зөвлөлд нэгдсэн тухайн сургуулийн 20-с доошгүй тооны оюутан байх ба анги бүрээс нэг төлөөлөл заавал байна.

11.2. ОЗ-ийн дээд удирдлага нь ОТИС-ийн ОХ байна. ОЗ нь чиг үүргийнхээ дагуу алба, сектор байгуулан ажиллана.

Арван наймдугаар зүйл. ОЗ-ийн дарга түүний бүрэн эрх

12.1. ОЗ-ийн дарга гэж ОЗ-ийн нийт гишүүдийн хурлаар сонгогдсон, ОТИС-ын бакалаврын зэрэг горилохоор суралцаж байгаа өдрийн ангийн оюутан байх ОХ-ны гишүүн, ОЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулах эрх, үүрэг бүхий сонгуульт ажилтныг хэлнэ.

12.2. ОЗ-ийн дарга нь ОЗ-ийн удирдагч мөн.

12.3. ОЗ-ийн дарга дараах эрх эдэлнэ.

12.3.1. оюутантай холбоотой бүхий л харилцаанд ОЗ, сургуулийн нийт оюутнуудыг төлөөлөх,

12.3.2. дүрэм, журам, шийдвэр, санал, уриалга, мэдэгдэл гарган тухайлсан асуудлаар тодорхой байр суурь баримтлан ажиллах

12.3.3. ёс зүйн болон бусад зөрчил гаргасан ОЗ-ийн гишүүнд хариуцлага тооцох талаар ОЗ-ийн хуралд санал гаргах

12.3.4. ОЗ-ийн хурлыг даргалах, хүндэтгэн үзэх шалтгаантайгаар хурлын товыг өөрчлөх, ээлжит бус хурлыг зарлах

12.3.5. хүндэтгэн үзэх шалтгаантайгаар ОЗ-ийн гишүүнд чөлөө өгөх

12.3.6. оюутны зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааг албан ёсоор нээх

12.3.7. ОЗ-ийн гишүүдэд үүрэг даалгавар өгөх

12.3.8. ОЗ-ийн гишүүдэд ажлын хариуцлага тооцох

12.3.9. ОЗ-ийн гишүүдийг шагнал, урамшуулал, хөнгөлөлтөд нэр дэвшүүлэх, шагнах, урамшуулах

12.3.10. ОЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, үүрэгт ажлаас нь чөлөөлөх, гишүүнчлэлээс хасах талаар ОХ болон хуралд амаар болон бичгээр санал оруулах,

12.3.11. ОЗ-ийн төсвийг зарцуулах, хяна

12.3.12. ОХ, ОЗ-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах

12.3.13. ОЗ-ийн тэргүүний бүрэн эрхийн хугацаа 1 жил байх ба 1 удаа улиран сонгогдох эрхтэй.

12.3.14. Энэхүү дүрэмд заасан бусад эрх эдэлнэ.

12.4. ОЗ-ийн дарга дараах үүрэг хүлээнэ

12.4.1. ОХ-ны тэргүүн, ОТИС-ийн захиргаа, ОХ-ны чиглүүлэгч багш, ОХ-ны хурлаас өгсөн үүрэг даалгаврыг ОЗ-ийн хурал дээр цаг тухайд нь мэдэгдэх, биелүүлэх,биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх

12.4.2. ОЗ-ийн үйл ажиллагааг байнгын тогтвортой явуулж, нийтэд нээлттэй байлгах

12.4.3. ОЗ-ийн өмч, эд хөрөнгийг хариуцах, хүлээн авч дараагийн даргад хүлээлгэн өгөх

12.4.4. Бүтэц сургуулийн оюутан ОЗ-ийн гишүүдээс гаргасан саналыг хүндэтгэн үзэж хэрэгжүүлэх боломцоог хангах, хамтран ажиллах

12.4.5. ОХ, ОЗ-ийн нэр төр, үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах

12.4.6. Асуудлыг олонхын саналаар шийдэж, цөөнхийн саналыг хүндэтгэн сонсох

12.4.7. Бусад ОЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

12.4.8. ОЗ-ийн даргын хувьд энэ дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих

12.4.9. Албан үүргээ гүйцэтгэж чадахгүй бол өөрийн хүсэлтээр албан тушаалаасаа чөлөөлөгдөх

12.4.10. ОЗ-ийн үйл ажиллагаа болон ОЗ-ийн нэр хүндтэй холбоотой асуудалд гишүүдийн нэрийн өмнөөс хариуцлага хүлээх

12.4.11. Өөрийн үйл ажиллагааны улмаас үүссэн хариуцлагыг бүрэн хүлээх

12.4.12. Дүрэмд заасан бусад үүрэг хүлээнэ.

Арван есдүгээр зүйл. ОЗ-ийн НБД

13.1. ОЗ-ийн НБД гэж ОЗ-ийн хурлаас сонгогдсон, ОТИС-ын бакалаврын зэрэг горилохоор суралцаж байгаа өдрийн ангийн оюутан байх ба ОЗ-ийн даргыг орлох, төлөөлөх, ОЗ-ийн хурлын протоколыг үнэн зөв стандартын дагуу хөтлөх эрх үүрэг бүхий сонгуульт ажилтныг хэлнэ.

13.2. ОЗ-ийн НБД нь ОЗ-ийн хуралд саналын эрхтэй байна.

13.3. НБД дараах эрх эдэлнэ.

13.3.1. ОЗ-ийн тэргүүнийг түүний зөвшөөрлөөр орлох, төлөөлөх

13.3.2. ОЗ-ийн хурал дээр өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх

13.3.3. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хурлаас чөлөө авах

13.3.4. Бусад сонгуульт албан тушаалд нэрээ дэвшүүлэх

13.3.5. Өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх

13.3.6. Шагнал урамшуулал, ажил байдлын тодорхойлолт, тэтгэлэг авах

13.3.7. ОЗ-ийн НБД-ын бүрэн эрхийн хугацаа 1 жил байх ба 1 удаа улиран сонгогдож болно.

13.3.8. Дүрэмд заасан бусад эрх эдэлнэ

13.4. НБД дараах үүрэг хүлээнэ.

13.4.1. ОЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлын протоколыг цаг тухайд нь үнэн зөвөөр, стандартын дагуу хөтлөх, хурал даргалагчид шалгуулан гарын үсэг зуруулан баталгаажуулах

13.4.2. ОЗ-ийн бичиг хэргийг баримтжуулан архивжуулах

13.4.3. ОЗ-ийн тайлан, төсөв, төлөвлөгөөний төслийг ОХ-ны тэргүүн, үүрэг болгосноор цаг тухайд нь гаргаж байх

13.4.4. хурлын ирцийг үнэн зөвөөр бүртгэх, нээлттэй ил тод байлгах

13.4.5. хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг танилцуулах

13.4.6. хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд ээлжит болон ээлжит бус хуралд ирэх

13.4.7. ОХ, ОЗ-ийн дүрмийг дагаж мөрдөх

13.4.8. өөрийн үйл ажиллагааны улмаас Оюутны Зөвлөл, түүний үйл ажиллагаа, бусдад учруулсан хохирлыг бүрэн хариуцах

13.4.9. дүрэмд заасан бусад үүрэг хүлээнэ.

Хорьдугаар зүйл. ОЗ-ийн гишүүн

14.1. ОЗ-ийн гишүүн гэж энэ дүрмийн дагуу сонгон шалгаруулалтад тэнцэн ангиа төлөөлөн ОЗ-ийн гишүүнд элсэн дүрэмд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа, ОТИС-ийн бакалаврын зэрэг горилохоор суралцаж байгаа өдрийн ангийн оюутан байна.

14.2. ОЗ-ийн гишүүнээр элсэхэд тавигдах шаардлагыг Оюутны Зөвлөл тухайн хичээлийн жилийн эхний сард багтаан гаргах ба жил бүр шинэчилнэ.

14.3. ОЗ-ийн гишүүн дараах бүрэн эрх эдэлнэ.

14.3.1. хүндэтгэн үзэх шалтгаанаар хурлаас, болон бусад үйл ажиллагаанаас чөлөө авах

14.3.2. ОЗ-ийн хурал дээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх

14.3.3. хурлаар асуудал хэлэлцүүлэхээр санал оруулах

14.3.4. сонгуульт албан тушаалд нэрээ дэвшүүлэх

14.3.5. өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх

14.3.6. ажил байдлын тодорхойлолт, шагнал урамшуулал, тэтгэлэг авах

14.3.7. ОЗ-ийн эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах

14.3.8. дүрэмд заасан бусад эрх

14.4. ОЗ-ийн гишүүн дараах үүрэг хүлээнэ

14.4.1. хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авснаас бусад тохиолдолд хуралд ирэх, 3 ба түүнээс дээш ирээгүй бол ОЗ-ийн гишүүнээс хасах.

14.4.2. ОХ, ОЗ-ийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар биелүүлэх

14.4.3. ОХ, ОЗ-ийн дүрмийг дагаж мөрдөх, түүнд захирагдах

14.4.4. ОХ, ОЗ-ийн хурлын шийдвэрийг биелүүлэх

14.4.5. удирдлага болон бусад гишүүдтэй хамтран ажиллах

14.4.6. хамт олны өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх

14.4.7. өөрийн үйл ажиллагааны улмаас учирсан үр дагаврыг бүрэн хариуцах

14.4.8. үүрэгт ажлаа гүйцэтгэж чадахгүй, ёс зүйн хувьд ОЗ-ийн гишүүнд тэнцэхгүй болсон тохиолдолд өөрийн хүсэлтээр ОЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх

14.4.9. дүрэмд заасан бусад үүрэг хүлээнэ.

Тавдугаар бүлэг. Бусад

Хорин нэгдүгээр зүйл. ОХ, ОЗ-ийн бүхий л сонгуульт ажилтанд тавигдах ерөнхий шаардлага

15.1. Дээрх албан тушаалд дараах шаардлагыг хангасан оюутан нэрээ дэвшүүлэх эрхтэй.

15.1.1. сайн дуураараа олон нийтийн ажилд оролцох чин хүсэлтэй, ачаалал даах, хариуцлага хүлээх, багаар ажиллах чадвартай, цаашид итгэл даахуйц.

15.1.2. ОХ, ОЗ-ийн дүрэм, журам, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээг харилцаандаа баримталж чаддаг, цаашид дүрмийн хүрээнд ажиллахаа хүлээн зөвшөөрсөн.

15.1.3. өөрийн үйл ажиллагааны улмаас бусдад гэм хор, хохирол учруулсан бол хариуцлага бүрэн хүлээх чадвартай.

15.1.4. Хичээлийн таслалтгүй, хичээлийн хажуугаар давхар ачаалал үүрэх, зохион байгуулалт хийх чадвартай.

Хорин хоёрдугаар зүйл. ОХ-ны тэргүүн, НБД, ОХ-ны гишүүн, ОЗ-ийн дарга, НБД, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх

16.1. Бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх хугацаа 1 сар байна. Ийнхүү түдгэлзүүлсэн хугацаанд уг үндэслэл, шалтгаан арилаагүй бол энэ дүрмийн 19 дүгээр зүйлд зааснаар үүрэгт ажлаас чөлөөлөх үндэслэл болно. Дараах үндэслэл байвал ОХ-ны тэргүүн, НБД, ОХ-ны гишүүн, ОЗ-ийн дарга, НБД, гишүүн байх, мөн ангийн дарга байх бүрэн эрхийг түдгэлзүүлнэ.

16.2. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүй, зан суртахууны хэм хэмжээг удаа дараа зөрчих.

16.3. ОХ, ОЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 удаа таслах

16.4. Энэхүү дүрэмд заасан эрх үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхгүй байх.

Хорин гуравдугаар зүйл. ОХ-ны тэргүүн, НБД, ОХ-ны гишүүн, ОЗ-ийн дарга, ГБД-ыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл

17.1. ОХ-ны тэргүүн, НБД, ОХ-ны гишүүн, ОЗ-ийн дарга, НБД-ыг үүрэгт ажлаас нь дараах үндэслэлээр чөлөөлнө.

17.1.1. өөрөө хүсэлт гаргасан

17.1.2. биеийн эрүүл мэндийн байдлаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон

17.1.3. сургуулийн захиргаа, тэнхимээс, ОХ, ОЗ-өөс тус тус албан тушаалд тэнцэхгүй тухай үндэслэл бүхий дүгнэлт, тодорхойлолт гаргасан.

17.1.4. энэ дүрмийн 18 дугаар зүйлд зааснаар

17.1.5. оюутан төгссөн.

17.1.6. гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол.

Хорин дөрөвдүгээр зүйл. Дүрмийн эх хувийг хадгалах, маргаан шийдвэрлэх

18.1. Дүрмийн эх хувийг ОХ-ны НБД хадгалах ба эх хувийг хуудас тус бүр дээр ОТИС-ийн тамгаар баталгаажилт хийсэн байна.

18.2. Дүрмийн дотоод агуулга, үг, утга санааны зөрчилдөөн гарахад дүрмийн эх хувийг баримтална.

Хорин тавдугаар зүйл. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, батлах

19.1. Энэхүү дүрмийг ОХ-ны хурлаар хэлэлцэн эцэслээд ОХ-ны чуулганаар дийлэнх олонхын /гуравны хоёр/ саналаар батална.

19.2. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг ОХ-ны гишүүн өөрийн санаачилгаар, ОЗ-ийн гишүүд ОЗ-ийн даргаараа дамжуулан ОХ-ны хуралд танилцуулах ба нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг ОХ-ны хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Ингэхдээ дийлэнх олонхын саналыг баримтална.

Хорин зургаадугаар зүйл. Хүчин төгөлдөр болох

20.1. Энэхүү дүрмийн нэмэлт өөрчлөлтийг 2024 оны 09 сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

---o0o---